

**ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН,
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН
ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

| | |
|---|----|
| 1. Аудитын гэрчилгээ | 3 |
| 2. Аудитын тайлан | 5 |
| 2.1. Оршил..... | 5 |
| 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага | 5 |
| 2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт | 5 |
| 2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин..... | 6 |
| 2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ | 6 |
| 2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал | 7 |
| 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар..... | 8 |
| 2.8 Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулга, аудитын дүн..... | 8 |
| 2.8.1 Мөнгөн хөрөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө | 8 |
| 2.8.2 Авлага..... | 9 |
| 2.8.3 Урьдчилгаа | 10 |
| 2.8.4 Бараа материал | 10 |
| 2.8.5 Үндсэн хөрөнгө | 11 |
| 2.8.6 Өр төлбөр | 12 |
| 2.8.7 Засгийн газрын хувь оролцоо..... | 13 |
| 2.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга..... | 14 |
| 2.10 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн | 16 |
| 2.10. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал | 18 |
| 2.11. Шилэн дансны мэдээлэл | 18 |
| 2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга..... | 19 |
| 2.13. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл..... | 19 |
| 3. Менежментийн захидал | 20 |
| 3.1 Балансын данстай холбоотой асуудал..... | 20 |
| 3.2 Удирдлагын дээд болон дотоод хяналттай холбоотой асуудал | 21 |
| 3.3 Батлагдсан төсөв, гүйцэтгэлтэй холбоотой асуудал..... | 21 |
| 3.4 Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэл | 22 |
| 3.5 Дотоод хяналт, Аудитын акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт | 23 |
| 4. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан..... | 24 |
| 4.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан..... | 24 |
| 4.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан..... | 25 |
| 4.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан | 26 |
| 4.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан..... | 27 |
| 4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан | 28 |
| 4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан | 30 |
| 5.Хавсралт..... | 31 |
| 5.1 Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт..... | 31 |
| 5.2 Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт..... | 36 |
| 5.3 Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар тогтоосон төлбөрийн актын нэгтгэл..... | 38 |
| 5.4 Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар хүргүүлсэн төлбөрийн албан шаардлагын нэгтгэл..... | 39 |

Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---------------|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| ҮАГ | Үндэсний аудитын газар |
| ТШЗ | Төсвийн шууд захирагч |
| ТТЗ | Төсвийн төвлөрүүлэн захирагч |
| ТЕЗ | Төсвийн ерөнхийлөн захирагч |
| ГХС | Гадаад харилцааны сайд |
| ГХЯ | Гадаад харилцааны яам |
| ЭСЯ | Элчин сайд яам |
| ЕКГ | Ерөнхий консулын газар |
| БТГ | Байнгын төлөөлөгчийн газар |
| ДТГ | Дипломат төлөөлөгчийн газар |
| ЗГНС | Засгийн газрын нөөц сан |
| ЗГНХ | Засгийн газрын нөөц хөрөнгө |
| ЗДНХ | Засаг даргын нөөц хөрөнгө |
| ДБҮЭГ | Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| ТӨҮГ | Төрийн өмчит үйлдвэрийн газар |
| ТБОНӨХБАҮХАТХ | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль |
| ТНБД | Төрийн нарийн бичгийн дарга |
| СЭЗХ | Санхүү эдийн засгийн хэлтэс |



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙД
Д.ЦОГТБААТАР ТАНАА

2020 04.24 № 1320
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.


Аудитаар Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг хариуцлага

Төсвийн ерөнхийлөн захирагч нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.



Д.ЗАНДАНБАТ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Төсвийн ерөнхийлөн захирагч Д.Цогтбаатар танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох, хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг хангаж ажиллах талаарх зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, НББОУС, СТОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, НББОУС, СТОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 4 дүгээр сарын 13-аас 2020 оны 4 дүгээр сарын 21-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 4 дүгээр сарын 24-ний өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын ахлах аудитор П.Чанцалдулам гүйцэтгэв.

Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 4 дүгээр сарын 03-ны өдрийн 08/1752 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе

шатны ажлыг гүйцэтгэн, шат шатны чанарын хяналт хийж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитыг Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, НББОУС, СТОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болгож, батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлэв.

2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Гадаад харилцааны яамны эрхэм зорилгыг “Монгол Улсын аюулгүй байдал, үндэсний хөгжилд олон улсын таатай гадаад орчинг бүрдүүлэх, дэлхийн улс орнуудтай бодит харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэхэд оршино” гэж тодорхойлсон байна.

Дээрх зорилгыг хэрэгжүүлэхдээ “Монгол Улсын гадаад харилцааг үндэсний аюулгүй байдлын болон гадаад бодлогын үзэл баримтлалд тодорхойлсон зарчим, чиглэлээр улс орны болон дэлхий дахины улс төр, эдийн засгийн шинэ нөхцөл байдалтай уялдуулан тууштай хэрэгжүүлж, үндэсний язгуур эрх ашиг, тогтвортой хөгжлийн зорилгод нийцсэн бие даасан, нээлттэй, олон тулгуурт гадаад бодлогыг идэвхтэй явуулах, гадаад бодлогын залгамж чанар, нэгдмэл байдлыг эрхэмлэж, Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, олон улсын хамтын нийгэмлэгт эзлэх байр суурийг бэхжүүлэх, гадаад эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх үйл ажиллагааг тууштай явуулах зорилтуудыг удирдлага болгоно” гэж үйл ажиллагааны зорилтыг тодорхойлсон байна.

Үйл ажиллагааны чиглэл: Засгийн газрын 2016 оны 81 дүгээр тогтоолоор Гадаад харилцааны яамны үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах таатай гадаад орчныг бүрдүүлэх;
- Гадаад худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх замаар Монгол Улсын хөгжлийн таатай гадаад орчныг бүрдүүлэх;
- Гадаад сурталчилгаа, соёлын харилцааг хөгжүүлэх, хилийн чанад дах монгол иргэд, сургууль, цэцэрлэг, холбоо, нийгэмлэгийн үйл ажиллагаанд бодит дэмжлэг үзүүлэх;
- Монгол Улсын иргэд, хувийн хэвшлийн хууль ёсны эрх ашиг, сонирхлыг хилийн чанадад хамгаалах зэрэг болно.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Сангийн яамны 2019 оны 74 дүгээр тушаалаар “Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны хэмнэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих” журам;
- Гадаад харилцааны сайдын 2019 оны 08/6836 болон 8/7397 дугаартай албан бичгээр батлагдсан зарим зардал хүрэлцэхгүй байгаа тул журмын дагуу зардал хооронд зохицуулалт хийж, 2019 оны төсвийн хуваарьт өөрчлөлт оруулсан;
- Нийгмийн даатгалын тухай хуулиар нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээ өөрчлөгдсөн;
- Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тушаалаар баталсан “Жишиг норм батлах тухай” автомашины хэрэглээний норм норматив өөрчлөгдсөн байна.

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг

шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь 2013 онд боловсруулагдаж, түүнээс хойш өөрчлөгдсөн стандарт, хууль тогтоомж, Сангийн сайдын баталсан болон бусад батлагдсан заавар журмын өөрчлөлтийг тусгаагүй байгаа нь санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, нягтлан бодогчид болон гадаад оронд суугаа Дипломат төлөөлөгчийн газруудын санхүүгийн ажилтнуудад баримтлах бодлого, арга зүй, гарын авлага дутмагаас бүртгэл, тайлагналын алдаа үүсэх сөрөг үр дагавартай байна.

Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтыг үнэлэхэд дотоод хяналт үр нөлөөтэй боловч төсвийн ерөнхийлөн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар илэрсэн нийт алдаа зөрчлийн дүн өмнөх оноос 3,001.2 сая төгрөгөөр өссөн байгаа нь аудитаар илэрсэн нийтлэг алдаа зөрчлийг арилгах талаар харьяа байгууллагуудад онлайн сургалт зохион байгуулж, зөвлөмж зөвлөгөө өгөх, хэвлэл мэдээллээр гарч буюу залилангийн шинжтэй асуудалд анхаарал хандуулан аудитын төлөвлөгөөндөө эрсдэлийг оновчтой тусгаж, ажиллах шаардлагатайг харуулж байна.

Гадаад харилцааны яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас тайлант онд нийт 37 хяналт, үнэлгээ, шинжилгээний ажлыг төлөвлөн, хэрэгжүүлж нийт 36 тайлан, танилцуулга боловсруулж, 189 зөвлөмж өгч, хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын үр дүнг баталгаажуулах, үйл ажиллагааны болон санхүүгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх, сахилга хариуцлагыг дээшлүүлэх чиглэлд 13 зөвлөмж гаргаж, Төрийн нарийн бичгийн даргын албан даалгаврыг Гадаад харилцааны яамны газар нэгж, ДТГ-уудад хүргүүлж ажилласан байна.

Тайлант онд ГХЯ-ны дотоод аудитын албанаас батлагдсан төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлсэн хяналт, шинжилгээний ажлаас товч дурдвал:

- Шведийн Хаант Улс, Итали, Франц, Кувейт, Сингапур, Япон Улсад суугаа ЭСЯ, Швейцарын Холбооны Улсад суугаа БТГ, БНСУ-ын Пусан, Хонконг, Макао, Туркийн Истанбул хотод суугаа ЕКГ-уудын санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийж шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгах, цаашид зөрчилгүй ажиллах талаар холбогдох газруудад зөвлөмж өгч, Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн даргын зааварлах захидлыг боловсруулж, ДТГ-т хүргүүлсэн,
- УАГ болон Сангийн яамнаас хийсэн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулах тал дээр арга хэмжээ авч, ДТГ-аас биелэлтийг гаргуулж үр дүнг тооцсон;
- “Шилэн дансны тухай хууль”-ийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд 2019 онд 3 удаа хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, хуулийн хэрэгжилтийг салбарын хэмжээнд 98.3 хувийн гүйцэтгэлтэй гэж дүгнэсэн;
- Гадаад харилцааны сайдын 2018, 2019 оны тушаалын хэрэгжилтийн явц, Иргэдэд туслах сангийн 2018-2019 оны үйл ажиллагаа, дипломат болон албан паспорт олголтод эрсдэлийн үнэлгээ, ДТГ-ын төсвийн төлөвлөлт, хуваарилалт, албан хаагчдын паспорт, автомашины ашиглалт, өндөр дээд түвшний албан тушаалтнуудын 2014-2018 онд хэрэгжүүлсэн 84 айлчлалын мөрөөр хэрэгжүүлэх төлөвлөгөөний биелэлтийг гаргах, үнэлэх зэрэг асуудлуудад дотоод аудитыг гүйцэтгэж, дүнг Дотоод аудитын хорооны хурлаар хэлэлцүүлж, зөвлөмж гарган биелэлтийг хэрэгжүүлж ажиллажээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж

авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 8 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 9 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшнийг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг 2019 оны эхний хагас жилийн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүн 56,419.4 сая төгрөгийн 2 хувь буюу 1,128.4 сая төгрөгөөр тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 3,215.3 сая төгрөгөөр тогтоосон нь 2019 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаарх суурь үзүүлэлт буюу санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардал 160,765.6 сая төгрөгөөс 2 хувиар тооцсонтой холбоотой болно.

2.8 Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулга, аудитын дүн

2.8.1 Мөнгөн хөрөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 6,234.6 сая, эцсийн үлдэгдэл 7,569.8 сая төгрөг болж, 1,335.2 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|-------------------------------------|----------------|-----------------|---------------------------|
| <u>Касст байгаа бэлэн мөнгө</u> | 689.0 | 516.6 | (172.4) |
| Төгрөг | 2.6 | 9.6 | 7.0 |
| Гадаад валют | 686.4 | 500.4 | (186.1) |
| Нэмэлт санхүүжилт | | 6.7 | 6.7 |
| <u>Банкинд байгаа бэлэн мөнгө</u> | 5,064.8 | 4,801.1 | (263.7) |
| Төгрөг | 1,287.2 | 1,300.1 | 12.9 |
| Төрийн сангийн харилцах | 4.2 | 4.2 | - |
| Арилжааны банк дахь харилцах | 1,283.0 | 1,126.6 | (156.4) |
| Нэмэлт санхүүжилтийн арилжааны банк | - | 169.3 | 169.3 |
| Гадаад валют | 3,777.6 | 3,501.0 | (276.6) |
| Арилжааны банк дахь харилцах | 3,777.6 | 3,501.0 | (276.6) |
| <u>Замд яваа мөнгөн хөрөнгө</u> | 480.7 | 2,252.0 | 1,771.3 |
| Дүн | 6,234.6 | 7,569.8 | 1,335.2 |
| <i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i> | | | |
| Төсөвт байгууллага | 3,781.1 | 4,717.0 | 935.9 |
| Төсөл/ сан | 41.0 | - | (41.0) |
| Төрийн сан | | | - |
| ТӨҮГ болон ОНӨҮГ | 2,412.5 | 2,852.8 | 440.3 |
| Дүн | 6,234.6 | 7,569.8 | 1,335.2 |

Эх сурвалж: Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Банкинд байршиж буй 4,801.1 сая төгрөгөөс гадаад валютаарх үлдэгдэл 3,501.0 сая төгрөг байна. Үүнээс 1,775.3 сая төгрөг төсөвт байгууллагын, 1,725.7 сая төгрөг төрийн болон орон нутгийн өмчит байгууллагын үлдэгдэл байна. Замд яваа мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд ДТГ-ын нийт 2,252.0 сая төгрөгийн үлдэгдэл тайлагнагдсанаас 1,849.0 сая төгрөг Москва дахь

ЭСЯ-ны барилгын их засварын зардлын санхүүжилт, Дели, Прага, Камберра дахь ЭСЯ-ны 146.0 сая, Эрээн, Бишкек дэх ЕКГ-ын 257.0 сая, нийт 403.0 сая төгрөг нь харилцах данснаас улсын төсөвт төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгөтэй холбоотой байна.

2.8.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 5,056.0 сая, эцсийн үлдэгдэл 13,964.1 сая төгрөг болж, 8,908.1 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №2 Авлагын үлдэгдэл /сая төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|-------------------------------------|----------------|-----------------|------------------------|
| Ажиллагчидтай холбогдсон авлага | 11.5 | 115.7 | 104.2 |
| Татаас, санхүүжилтийн авлага | 540.7 | 240.9 | -299.8 |
| Дансны авлага /ТӨҮГ/ | - | 643.6 | 643.6 |
| Татвар, НДШ-ын авлага /ТӨҮГ/ | - | 8.8 | 8.8 |
| Бусад авлага | 4,503.7 | 12,955.0 | 8,451.3 |
| Байгууллагаас авах авлага | 4,063.2 | 12,499.9 | 8,436.7 |
| Хувь хүмүүсээс авах авлага | 440.5 | 455.1 | 14.6 |
| Дүн | 5,056.0 | 13,964.1 | 8,908.1 |
| <i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i> | | | |
| Төсөвт байгууллага | 4,402.8 | 4,328.8 | (74.0) |
| Төсөл/ сан | - | - | - |
| Төрийн сан | - | - | - |
| ТӨҮГ болон ОНӨҮГ | 653.2 | 9,635.3 | 8,982.1 |
| Дүн | 5,056.0 | 13,964.1 | 8,908.1 |

Эх сурвалж: Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын үлдэгдэл өмнөх оноос 2.7 дахин их буюу 8,908.1 сая төгрөгөөр өссөн нь Төрийн өмчит үйлдвэрийн газрын авлагын өсөлт нөлөөлжээ.

ТЕЗ-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд эрхлэх асуудлын хүрээний 8 байгууллага, нэгжийн санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс Монголын мянганы сорилтын сан ТӨҮГ-ын санхүүгийн тайлан шинээр нэмж нэгтгэгдэж, нийт 8,962.3 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг тайлагнасанатай холбоотойгоор авлага нэмэгджээ.

ТЕЗ-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн авлагын үлдэгдэл 13,964.1 сая төгрөгөөс 2,301.2 сая төгрөгийн авлага нь тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй байна.

Авлагын үлдэгдэлд олон жилийн насжилттай 1,787.7 сая төгрөгийн дараах авлага байна. Үүнд:

- Астана дахь ЭСЯ-д барилга, газрын маргаантай холбоотой 10 жилийн өмнө үүссэн 1,641.5 сая төгрөгийн авлага;
- Берлин дэх ЭСЯ-ны 2013, 2015 онуудад буцсан ажиллагсадтай холбоотой үүссэн 9.6 сая төгрөгийн авлага;
- Гадаад харилцааны яамны 2010-2014 онд үүссэн дараа тайлангийн томиллолт, цалингийн тооцоотой холбоотой үүссэн 136.6 сая төгрөгийн тодорхойгүй, эрсдэлтэй авлага байна.

Эдгээр нь 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд авлагын үлдэгдлийг өсгөх, эргэн төлөгдөхгүй, найдваргүй авлага болох эрсдэлтэй байгаад анхаарал хандуулж, уг авлагыг барагдуулах талаар арга хэмжээг авч ажиллах шаардлагатай байна.

Аудитын илрүүлэлт:

- Авлагын үлдэгдэл 2,301.2 сая төгрөгийн тооцоог нийлж баталгаажуулаагүй /ДТГ 1,697.0 сая, ГХЯ 139.1 сая, ДБҮЭГ 464.1 сая, ЮНЕСКО-гийн Монголын үндэсний комисс 1.0 сая/

- Олон жил болсон 1,787.7 сая төгрөгийн авлагыг барагдуулаагүй /ДТГ 1,651.1 сая, ГХЯ 136.6 сая/

2.8.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эхний үлдэгдэл 33.0 сая, эцсийн үлдэгдэл 330.5 сая төгрөг болж, 297.5 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №3 Урьдчилгаа дансны үлдэгдэл /сая төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|-------------------------------------|----------------|-----------------|------------------------|
| Урьдчилж гарсан зардал | 33.0 | 214.6 | 181.6 |
| Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа | - | 115.9 | 115.9 |
| Дүн | 33.0 | 330.5 | 297.5 |
| <i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i> | | | |
| Төсөвт байгууллага | 33.0 | 330.5 | 297.5 |
| Төсөл/ сан | | | |
| ТӨҮГ болон ОНӨҮГ | | | |
| Дүн | 33.0 | 330.5 | 297.5 |

Эх сурвалж: Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урьдчилгаа дансны үлдэгдэл тайлант онд үүссэн 323.9 сая төгрөгийн бараа ажил, үйлчилгээний төлбөрөөр нэмэгдсэн бол ГХЯ түүх соёлын дурсгалт зүйлд 26.3 сая төгрөгийн уран зургийг урьдчилж гарсан зардлаас хөрөнгөөр бүртгэснээс буурсан байна. Үүнд:

- ГХЯ-ны урьдчилж гарсан зардал дансны үлдэгдлийн 61.9 хувь буюу 50.9 сая төгрөг нь 2020 оны 1 дүгээр сарын 14-31-ний өдрүүдэд хийгдэх ерөнхийлөгчийн айлчлалын бүрэлдэхүүний томилолтын урьдчилгаа, 24.7 сая төгрөг нь “галт хан” мэдээллийн аюулгүй байдлын программын лицензийн 2 жилийн урьдчилгаа төлбөр байна.
- ДТГ-ын санхүүгийн нэгтгэсэн тайланд 115.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа тайлагнагдсанаас хөрөнгө оруулалтын санхүүжилтээс 36.0 сая, давсан орлогоос 79.9 сая төгрөгийг тус бүр Бээжин дэх ЭСЯ-ны Консулын хэлтсийн виз олгох хэсгийг өргөтгөх их засварын ажлын зардлын санхүүжилтийн урьдчилгаа байна.
- ЮНЕСКО-гийн Монголын үндэсний комисс нь тайлант онд ЮНЕСКО-ийн Парис дах төвөөс оролцооны 4 хөтөлбөр хэрэгжүүлж, 179.7 сая төгрөгийн төсөл хэрэгжихээс 47.3 сая төгрөгийн тооцоо хийгдэж, 132.4 сая төгрөгийг урьдчилж төлсөн зардал дансанд тусгагдсан байна.

2.8.4 Бараа материал

Бараа материалын эхний үлдэгдэл 2,038.1 сая, эцсийн үлдэгдэл 3,827.5 сая төгрөг болж, 1,789.4 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №4 Бараа материалын үлдэгдэл /сая төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|------------------------------|----------------|-----------------|------------------------|
| Түүхий эд материал | 259.5 | 1,034.5 | 774.9 |
| Тусгай зориулалттай материал | 259.5 | 1,034.5 | 774.9 |
| Бэлэн бүтээгдэхүүн | 5.4 | 15.2 | 9.9 |
| Хангамжийн материал | 1,773.2 | 2,777.8 | 1,004.5 |
| Бичиг хэргийн материал | 48.0 | 65.1 | 17.1 |
| Аж ахуйн материал | 71.0 | 109.8 | 38.8 |
| Сэлбэг хэрэгсэл | 49.3 | 834.9 | 785.6 |
| Түлш, шатах тослох материал | 3.7 | 36.0 | 32.2 |
| Барилгын засварын материал | 13.9 | 16.3 | 2.3 |
| Хүнсний материал | 196.4 | 203.0 | 6.5 |
| Бусад хангамжийн материал | 1,390.8 | 1,512.8 | 122.0 |

| Дүн | 2,038.1 | 3,827.5 | 1,789.4 |
|-------------------------------------|----------------|----------------|----------------|
| <i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i> | | | |
| Төсөвт байгууллага | 1,544.0 | 2,601.7 | 1,057.7 |
| Төсөл/ сан | 11.4 | - | (11.4) |
| ТӨҮГ болон ОНӨҮГ | 482.7 | 1,225.8 | 743.0 |
| Дүн | 2,038.1 | 3,827.5 | 1,789.4 |

Эх сурвалж: Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын үлдэгдлийн өсөлтөд хамгийн их нөлөөлсөн данс нь тусгай зориулалтын материал бөгөөд ДТГ нь тайлант онд ЗГНС-гаас зээл авч 1,153.9 сая төгрөгийн 1,000.0 мянган ширхэг визний хуудсыг Эвер волл Си Пи ЭС Монголиа ХХК-иар гүйцэтгүүлсэнтэй холбоотой үүссэн байна.

Мөн сэлбэг хэрэгсэл данс 785.6 сая төгрөгөөр өссөн нь Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар ТӨҮГ нь тайлант онд ТӨБЗГ-ын 2019 оны 120 дугаар тогтоолоор буцалтгүй тусламжийн хүрээнд нийт 5,441.5 сая төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг бүртгэж, 2019 оны А-1/3882 тоот албан бичгээр нийт 4,680.6 сая төгрөгийн үнэ бүхий хөрөнгөөс Гадаад харилцааны яаманд 884.1 сая, Авлигатай тэмцэх газарт 331.2 сая, Тагнуулын ерөнхий газарт 135.2 сая, Цагдаагийн ерөнхий газарт 330.2 сая, Радио, телевизийн сүлжээний газарт 723.1 сая, Удирдлагын академид 199.9 сая, Үндэсний батлан хамгаалахын их сургуульд 1,035.6 сая, ЮНЕСКО-ийн Монголын үндэсний комисст 167.0 сая төгрөгийн хөрөнгийг балансаас балансад шилжүүлж, үлдсэн 760.8 сая төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг бараа материал дансанд бүртгэснээс голлон шалтгаалсан байна.

Бараа материалын үлдэгдэлд тайлант оны эцэст худалдан авсан нийт 111.3 сая төгрөгийн түлш, шатах тослох материал болон хангамжийн бараа материалыг их хэмжээгээр нөөцөлжээ. Тухайлбал:

- Түлш, шатах тослох материалын үлдэгдэл 31.1 сая төгрөг бөгөөд өмнөх оны мөн үеэс 9.7 дахин буюу 27.9 сая төгрөгөөр өссөн нь Женев дэх Байнгын төлөөлөгчийн газрын 19.4 сая, Бээжин дэх ЭСЯ-ын 5.6 сая төгрөгийн шатахуун үлдэгдэл бөгөөд тайлант оны эцэст их хэмжээний худалдан авалт хийж, нөөцөлсөн;
- ГХЯ нь тайлант онд 150.4 сая төгрөгийн худалдан авалт хийснээр 33.9 сая төгрөгийн бараа материалын нөөц нэмж үүсгэсэн. Үүнд 3.4 сая төгрөгийн барилгын засварын материал, 19.6 сая төгрөгийн ашиглалтад байгаа хангамжийн материал, 5.6 сая төгрөгийн 89 ш принтерийн хор, 3.6 сая төгрөгийн 377 боодол бичгийн цаас, 4.5 сая төгрөгийн Ойр дайдын оронтой түншилсэн түүхээс ном 300 ширхэг, 5.0 сая төгрөгийн бэлэг дурсгал зэрэг бараа материалын нөөц;
- ДБҮЭГ нь тайлант онд 46.3 сая төгрөгийн зочид буудал, зоогийн үйлчилгээнд шаардлагатай бага үнэтэй түргэн элэгдэх зүйлс худалдан авсан зэрэг нь бараа материалын үлдэгдэл өсөх шалтгаан болжээ.

2.8.5 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 381,049.1 сая, эцсийн үлдэгдэл 361,478.6 сая төгрөг болж, 19,570.5 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №5 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|--------------------------------|------------------|------------------|---------------------------|
| Газар | 33,342.5 | 33,342.5 | - |
| Биет хөрөнгө | 319,862.8 | 300,325.9 | (19,536.9) |
| Барилга, байгууламж, орон сууц | 323,129.6 | 326,265.7 | 3,136.1 |
| Хуримтлагдсан элэгдэл | -14,685.18 | -39,509.98 | (24,824.8) |
| Авто-тээврийн хэрэгсэл | 11,843.1 | 13,698.8 | 1,855.7 |
| Хуримтлагдсан элэгдэл | -9,601.61 | -10,400.43 | (798.8) |

| | | | |
|-------------------------------------|------------------|------------------|-------------------|
| Машин тоног төхөөрөмж(компьютер) | 5,916.6 | 7,287.1 | 1,370.5 |
| Хуримтлагдсан элэгдэл | -4,382.84 | -4,615.43 | (232.6) |
| Тавилга, аж ахуйн эд хогшил | 6,825.0 | 6,758.7 | (66.3) |
| Хуримтлагдсан элэгдэл | -4,494.06 | -4,591.98 | (97.9) |
| Зам, гүүрийн байгууламж | 461.1 | 464.8 | 3.7 |
| Хуримтлагдсан элэгдэл | -461.08 | -461.77 | (0.7) |
| Түүх соёл, музейн дурсгалт зүйлс | 61.3 | 87.7 | 26.3 |
| Бусад үндсэн хөрөнгө | 303.0 | 378.4 | 75.4 |
| Хуримтлагдсан элэгдэл | -271.09 | -255.61 | 15.5 |
| Дуусаагүй барилга, байгууламж | 5,197.5 | 5,197.5 | - |
| Ном | 21.5 | 22.5 | 1.1 |
| Биет бус хөрөнгө | 27,843.8 | 27,810.1 | (33.7) |
| Программ хангамж | 284.4 | 283.2 | (1.1) |
| Хуримтлагдсан элэгдэл | -136.74 | -169.32 | (32.6) |
| Бусад биет бус хөрөнгө | 27,696.2 | 27,696.2 | - |
| Дүн | 381,049.1 | 361,478.5 | (19,570.6) |
| <i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i> | | | |
| Төсөвт байгууллага | 355,690.5 | 335,784.2 | (19,906.3) |
| Төсөл/ сан | 50.5 | - | (50.5) |
| ТӨҮГ болон ОНӨҮГ | 25,308.1 | 25,694.3 | 386.2 |
| Дүн | 381,049.1 | 361,478.5 | (19,570.6) |

Эх сурвалж: Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд үндсэн хөрөнгө төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 5,229.4 сая, балансаас баланст шилжүүлэн авсан 234.2 сая, үнэ төлбөргүй хандиваар авсан 1,302.7 сая, бусад ангилал 2,070.8 сая төгрөгөөр нэмэгдсэн, балансаас баланст шилжүүлсэн 349.2 сая, ТӨБЗГ-ын 2019 оны 31, 32, А/2/2227 тоот албан бичгээр акталсан 2,086.4 сая төгрөгөөр хасагдсан байна.

Тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан бэлтгэсэн хөрөнгөөс ДТГ 1,871.6 сая, ГХЯ 198.2 сая төгрөгийн хөрөнгийг Сангийн яам болон ТӨБЗГ-аас зөвшөөрөл авч, үйл ажиллагааны давсан орлогоос санхүүжүүлсэн бол ДТГ-т 2,803.4 сая, ГХЯ-д 63.5 сая төгрөгийн тус тус хөрөнгө оруулалт хийгдсэн байна

Дээрх санхүүжилтээс 18 ЭСЯ-нд 1,737.4 сая төгрөгийн автомашин худалдан авч парк шинэчлэл хийсэн, 8 ЭСЯ болон ГХЯ-ны их засварт 2,465.4 сая төгрөгийн сайжруулалт хийж, 4 ЭСЯ болон ГХЯ-д 736.6 сая төгрөгийн тоног төхөөрөмж худалдан бэлтгэжээ.

Дуусаагүй барилга, байгууламж дансанд 5,197.5 сая төгрөгийн өртөгтэй ГХЯ-ны “Ёслол хүндэтгэлийн өргөө”-ний барилга бүртгэлтэй байна. Уг барилгын угсралтын ажил дуусаж 2017 оны 10 дугаар сард ашиглалтад оруулсан боловч улсын комиссын акт гараагүй, барилгын гүйцэтгэгчээр сонгогдсон анхны компанитай санхүүгийн тооцооны асуудлаар маргаантай, шүүхийн шатанд хэлэлцэгдэж байгаагаас шалтгаалж барилга, байгууламжийн дансанд шилжүүлээгүй, одоог хүртэл дуусаагүй барилга, байгууламж дансанд тайлагнагдсаар байна.

2.8.6 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 783.6 сая, эцсийн үлдэгдэл 11,048.6 сая төгрөг болж, 10,265.0 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №6 Нийт өр төлбөрийн үлдэгдэл /сая төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---|----------------|-----------------|------------------------|
| БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН | 783.6 | 11,046.8 | 10,263.2 |
| Өглөг | 783.6 | 11,043.1 | 10,259.5 |
| Ажилчидтай холбогдсон өглөг | 25.9 | 15.1 | -10.8 |
| Бараа үйлчилгээний зардлын өглөг | - | 11.4 | 11.4 |

| | | | |
|--------------------------------------|--------------|-----------------|-----------------|
| Бусад өглөг | 757.7 | 11,016.5 | 10,258.8 |
| Байгууллагад төлөх өглөг | 742.8 | 10,097.0 | 9,354.2 |
| Хувь хүмүүст төлөх өглөг | 13.6 | 38.8 | 25.2 |
| Татварын өглөг /ТӨҮГ/ | - | 119.8 | 119.8 |
| НДШ-ийн өглөг /ТӨҮГ/ | 1.3 | - | -1.3 |
| Дансны өглөг /ТӨҮГ/ | - | 760.9 | 760.9 |
| Урьдчилж орсон орлого | - | 3.8 | 3.8 |
| Бусад урьдчилж орсон орлого | - | 3.8 | 3.8 |
| УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН | - | 1.8 | 1.8 |
| Урт хугацаат зээл | - | 1.8 | 1.8 |
| Төгрөг | - | 1.8 | 1.8 |
| Хойшлогдсон өр төлбөр /ТӨҮГ/ | - | 1.8 | 1.8 |
| НИЙН ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН | 783.6 | 11,048.6 | 10,265.0 |
| <i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i> | | | |
| Төсөвт байгууллага | 726.2 | 643.1 | (83.1) |
| Төсөл, сан | | | - |
| ТӨҮГ болон ОНӨҮГ | 57.4 | 10,405.5 | 10,348.1 |
| ДҮН | 783.6 | 11,048.6 | 10,265.0 |

Эх сурвалж: Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт өр төлбөрийн үлдэгдэл өмнөх оноос 14 дахин их буюу 10,265.0 сая төгрөгөөр өссөн нь Төрийн өмчит үйлдвэрийн газрын өглөгийн өсөлт бөгөөд ТЕЗ-ын санхүүгийн нэгтгэсэн тайланд Монголын мянганы сорилтын сан ТӨҮГ-ын санхүүгийн тайлан шинээр нэгтгэгдэж, тайлант онд шинээр нэмэгдсэн нийт 9,614.5 сая төгрөгийн өглөгийн үлдэгдлийг тайлагнасангай холбоотой байна.

Нийт өр төлбөрийн 99.9 хувь буюу 11,046.8 сая төгрөг нь богино хугацаат өр төлбөр бөгөөд үүнээс 10,097.0 сая төгрөг нь байгууллагад төлөх өглөг байна. Мөн нийт өр төлбөрийн 97.0 хувь буюу 10,714.9 сая төгрөг нь тайлант онд шинээр үүссэн өглөг байгаа учраас батлагдсан төсөвт хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ зарцуулалтад нь хяналт тавьж, ажил гүйлгээний үлдэгдлийг баталгаажуулж, төлөх боломжтой өр төлбөрийг тайлант онд нь барагдуулж байх нь зүйтэй байна.

ТЕЗ-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн нийт өр төлбөрийн үлдэгдэл 11,048.6 сая төгрөгөөс 875.3 сая төгрөгийн өглөгийг тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй байна.

Урт хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар ТӨҮГ-ын 1.8 сая төгрөгийн хойшлогдсон татварын өр төлбөрийг бүртгэж, тайлагнасан байна.

Аудитын илрүүлэлт:

- Өр төлбөрийн үлдэгдэл 875.3 сая төгрөгийн тооцоог нийлж баталгаажуулаагүй /ДТГ 12.1 сая, ГХЯ 31.6 сая, ДБҮЭГ 781.4 сая, ЮНЕСКО-гийн Монголын үндэсний комисс 50.2 сая/

2.8.7 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 393,627.1 сая, эцсийн үлдэгдэл 376,121.8 сая төгрөг болж, 17,505.3 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №7 Нийт өр төлбөрийн үлдэгдэл /сая төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---------------------------------------|-------------------|-------------------|---------------------------|
| ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 393,627.1 | 376,121.8 | (17,505.3) |
| Засгийн газрын хувь оролцоо | 393,627.1 | 376,121.8 | (17,505.3) |
| Засгийн газрын оруулсан капитал | | | |
| /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 201,783.2 | 201,762.8 | (20.4) |
| Хуримтлагдсан үр дүн | (54,181.1) | (73,769.8) | (19,588.7) |
| Өмнөх үеийн үр дүн | (26,360.4) | (54,029.8) | (27,669.3) |

| | | | |
|-------------------------------------|------------------|------------------|-------------------|
| Тайлант үеийн үр дүн | (27,820.6) | (19,740.0) | 8,080.6 |
| Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 261,220.6 | 261,220.6 | - |
| Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | (15,195.6) | (13,091.8) | 2,103.8 |
| Дүн | 393,627.1 | 376,121.8 | (17,505.3) |
| <i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i> | | | |
| Төсөвт байгууллага | 364,580.8 | 347,060.6 | (17,520.2) |
| Төсөл, сан | 102.8 | - | (102.8) |
| ТӨҮГ болон ОНӨҮГ | 28,943.5 | 29,061.2 | 117.7 |
| Дүн | 393,627.1 | 376,121.8 | (17,505.3) |

Эх сурвалж: Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Цэвэр хөрөнгө өмчийн дүн 17,505.3 сая төгрөгөөр буурсан нь тайлант оны үр дүн 19,740.0 сая төгрөгөөр буурснаас голлон шалтгаалжээ.

Засгийн газрын оруулсан капитал данс 20.4 сая төгрөгөөр буурсан нь Далайд гарцгүй хөгжиж байгаа орнуудын олон улсын судалгааны төв буюу төсөл хэрэгжүүлэгч нэгж татан буугдсантай холбоотой өмчид гарсан өөрчлөлт байна.

Бодлогын өөрчлөлт алдааны залруулгад нийт 169.0 сая төгрөгийг бүртгэснээс 251.5 сая төгрөг нь төсөвт байгууллага, -82.5 сая төгрөг нь Далайд гарцгүй хөгжиж байгаа орнуудын олон улсын судалгааны төв буюу төсөл хэрэгжүүлэгч нэгжийн залруулга байна.

Дипломат байгууллагын үйлчилгээ эрхлэх газар ТӨҮГ нь тайлант онд нийт 17.7 сая төгрөгийн ногдол ашиг зарлан бүртгэж, тайлагнасан байна.

Гадаад оронд суугаа ДТГ-уудын санхүүгийн тайлангийн толилуулгын валютын хөрвүүлэлтийн зөрүүгээс 2,103.8 сая төгрөгийн олз үүссэн байна.

2.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсөв захирагч нь төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх 3 хөтөлбөрт зориулан 76,272.8 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 73,397.8 сая төгрөгийг урсгал зардалд, 2,875.0 сая төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 74,722.8 сая төгрөгийг улсын, 1,550.0 сая төгрөгийг үндсэн болох туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 73,345.1 сая төгрөгийн санхүүжилт олгож, 1,377.7 сая төгрөгийг дутуу олгосон байна.

Монгол улсын 2019 оны төсвийн тухай хуулиар ТЕЗ-ийн төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогыг Дипломат төлөөлөгчийн газар 20,000.0 сая, ГХЯ-ны туслах үйл ажиллагааны орлогыг 1,550.0 сая төгрөгийг бүрдүүлж төвлөрүүлэхээр тус тус баталжээ.

Дипломат төлөөлөгчийн газар төвлөрүүлэх 22,394.1 сая төгрөгийн үндсэн үйл ажиллагааны орлого бүрдүүлж, батлагдсан төсвөөс 2,394.1 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн нь визний хураамжийн орлого урьдчилж орсноос шалтгаалжээ.

ГХЯ туслах үйл ажиллагааны орлого 7,904.5 сая төгрөгийг бүрдүүлж, төсөвт байгууллагын үйл ажиллагааны давсан орлогоос 2,435.6 сая төгрөгийг нэмэлт санхүүжилтийн харилцах дансанд шилжүүлэн хөрөнгө бэлтгэсэн байна.

ГХЯ 560.0 сая, Олон Улсын хамтын ажиллагааны сан 990.0 сая төгрөгийн өөрийн орлого бүрдүүлж, санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гадаад харилцааны яам тайлант онд гүйцэтгэлээр 2,350.5 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 4.2 дахин давуулан биелүүлсэн нь Монгол улсад нэвтрэх гадаад

иргэдийн паспортад наах визийн хуудсыг үйлчилгээний хөлсний хамт 3 ам.доллар болгосон, дипломат болон албан паспортын төлбөртэй тус тус холбоотой байна.

Гадаад харилцааны яам тайлант онд туслах үйл ажиллагааны орлогоос 1,140.3 сая төгрөгийг улсын төсвийн байгууллагын үйл ажиллагааны давсан орлого, төсвийн зарлагын хэмнэлтийг зарцуулах тухай Сангийн сайдын 2019 оны 251 дүгээр тушаалаар эрх нээлгэн зарцуулжээ.

Тайлант онд харьяа байгууллагуудын төсөвт байгууллагын орлогын төлөвлөгөө 4,184.6 сая төгрөгөөр давж биелсэн нь орлогын төлөвлөгөөг үндэслэлгүй, хэт багаар баталсан харагдаж байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 67,808.0 сая төгрөг буюу 8,464.8 сая төгрөгөөр дутуу зарцуулж, 88.9 хувьтай байна. Батлагдсан төсөвт зардал бүлгийн дүнгээр хэтрээгүй боловч эдийн засгийн ангиллаар материаллаг дүнтэй илүү, дутуу зарцуулсан дараах зардлууд байна. Үүнд:

Үндсэн цалингийн зардал 1,741.2 сая төгрөгөөр илүү, нэмэгдэл цалингийн зардал 3,787.5 сая төгрөгөөр дутуу зарцуулсан нь гадаад оронд суугаа ДТГ-ын дэргэд 9 худалдааны төлөөлөгчийн газар нээхээр 1,225.9 сая төгрөгийн урсгал зардал төсөвлөсөн боловч эдгээр газрууд нь нээгдээгүйгээс нийт 1,012.5 сая төгрөгийн цалингийн зардал зарцуулагдаагүй.

Мөн Шанхай дах ЕКГ, Манжуур дах КГ-уудыг нээхээр тайлант онд нийт 1,274.1 сая төгрөгийн урсгал зардлын төсөв батлагдсан боловч Манжуур дах КГ нээгдээгүйгээс 439.2 сая төгрөг зарцуулагдаагүй, үүнээс цалингийн зардал 262.3 сая, Шанхай дах ЕКГ нь 2019 оны 10 дугаар сараас үйл ажиллагааг эхлүүлснээс шалтгаалан цалингийн зардал 171.8 сая төгрөгөөр тус тус дутуу зарцуулагджээ.

Зарим ДТГ-уудын тэргүүн нарын томилгоо хийгдээгүй хүлээгдэж байгаа, хугацааны дундуур томилогдсон, мөн орон тоо дутуу ажиллаж байгаагаас шалтгаалан цалингийн зардлаас гадна нийгмийн даатгалын шимтгэл, байрны түрээс, эрүүл мэндийн даатгал, хичээл сургалтын зардлууд зарцуулагдаагүй үлдсэн байна.

Бараа, үйлчилгээний бусад зардал 1,600.8 сая төгрөгөөр дутуу зарцуулсан нь Олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх 990.0 сая төгрөгийн хөтөлбөрийг Засгийн газрын 2019 оны 87 дугаар тогтоолоор татан буулгаснаас шалтгаалсан байна.

Мэдээлэл технологийн үйлчилгээний зардалд батлагдсан 990.0 сая төгрөгийн арга хэмжээ хийгдээгүйгээс төсөвт зардал дутуу зарцуулагджээ.

Засгийн газрын гадаад шилжүүлгийн зардал 1,089.3 сая төгрөгөөр дутуу зарцуулагдсан нь олон улсын гишүүний татварыг тооцоо судалгаагүй, үндэслэл муутай төлөвлөгдсөнөөс шалтгаалжээ.

Хөрөнгө оруулалтын 2 төсөл, арга хэмжээнд 2,875.0 сая төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 2,866.9 сая төгрөгийн санхүүжилтийг олгожээ.

Ажил үйлчилгээг гүйцэтгэхдээ дээрх хөрөнгийн худалдан авалт, хөрөнгө нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгох тендер шалгаруулалтыг ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.7 дахь хэсэгт "..... Хилийн чанад дахь Дипломат төлөөлөгчийн газрын худалдан авах ажиллагааг зохион байгуулахад төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас авсан зөвшөөрлийн үндсэн дээр нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхгүй байж болно" гэж заасны дагуу Сангийн сайдын 2019 оны 12 дугаар сарын 30-ны 6-1/8597 тоот албан бичгээр холбогдох зөвшөөрлийг авч суутган барьцаа данс болон захиалагчийн хяналтын дансанд ямар нэгэн тооцоо хийлгүйгээр шууд гадаад оронд суугаа ДТГ-уудад санхүүжилтийг олгосон байна.

Нэмэлт төсөв: Төрийн болон орон нутгийн өмчит бус хуулийн этгээдээс авсан хандив, тусламж 962.4 сая, Засгийн газрын нөөц хөрөнгөөс 4,041.7 сая, дээд шатны төсвийн захирагчаас 128,7 сая, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 5,112.0 сая, нийт 10,244.8 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс Мянганы сорилын корпорацид 221.9 сая, Засгийн газрын тогтоолын дагуу 4,040.3 сая, хөрөнгийн зардалд 1,675.6 сая, үйл ажиллагаанд 3,321.9 сая төгрөгийг зарцуулж, зарцуулаагүй үлдэгдэл 809.1 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлж, нэмэлт санхүүжилтийн харилцахад 176.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан байна.

2.10 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 1 төсвийн төвлөрүүлэн захирагч, 2 төсвийн байгууллага, 2 төрийн өмчит аж ахуйн нэгж, 2 тусгай сан, 1 төслийн нэгжийн, нийт 8 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 5 байгууллага аудитад хамрагдсан, 3 байгууллага /татан буугдсан 2 байгууллага, Монголын мянганы сорилтын сан ТӨҮГ/ аудитад хамрагдаагүй байна.

Аудитад хамрагдсан 5 харьяа байгууллагуудаас 1 байгууллагыг түүвэрт хамруулж, 4 байгууллагад дүгнэлт хүргүүлжээ. Үүнд: “Зөрчилгүй” 3, “Хязгаарлалттай” 1 /ЮНЕСКО-гийн Монголын үндэсний комисс/ дүгнэлт өгсөн байна.

Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 7,682.2 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 3,162.4 сая төгрөгийн алдааг залруулж, 138.3 сая төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 171.9 сая төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага, 4,209.6 сая төгрөгийн алдаа, зөрчилд 26 зөвлөмж өглөө.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэхдээ харьяа байгууллагуудын аудит хийсэн санхүүгийн тайлангаас зөрүүтэй нэгтгэсэн байна. Үүнд:

- Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайланд ЗГНХ, ЗДНХ, түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгийн орлого болон төвлөрүүлэх шилжүүлгийг 1.3 сая төгрөгөөр бууруулан бүртгэсэн, нэмэлт санхүүжилтийн дансны төвлөрүүлэх шилжүүлгийг 1.3 сая төгрөгөөр бууруулж, бараа үйлчилгээний бусад зардалд нэмж аудит хийсэн тайлангаас зөрүүтэй нэгтгэсэн, мөн хүүгийн орлого 142.1 сая төгрөгийг үнэ төлбөргүй хүлээн авсан орлогоор зөрүүлэн нэгтгэсэн;

- Төсвийн гүйцэтгэлийн тайланд 63.5 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн орлого, зардлыг аудит хийсэн тайлангаас зөрүүтэй нэгтгэсэн алдааг залруулав.

Төсвийн ерөнхийлөн захирагчид 3,176.5 сая төгрөгийн алдаа, зөрчилд өгсөн 5 зөвлөмжийг менежментийн захидалд дурдсан болно.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар

Дипломат төлөөлөгчийн газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нийт 43 байгууллагын санхүүгийн тайланг нэгтгэсэн байна.

Аудитаар нийт 3,672.2 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 2,531.3 сая төгрөгийн алдааг залруулж, 117.8 сая төгрөгийн 2 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 159.0 сая төгрөгийн

2 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 864.1 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 7 зөвлөмж өглөө.

Тайлант онд Монгол Улсаас гадаад оронд суугаа 18 ЭСЯ, 6 Ерөнхий консулын газар, 2 Байнгын төлөөлөгчийн газрын 2017 оны сүүлийн хагас жил, 2018 он, 2019 оны эхний хагас жилийн санхүүгийн үйл ажиллагаанд санхүүгийн тайлангийн аудит хийгдсэн ба аудитаар дараах анхаарал татахуйц асуудлуудад анхаарал хандуулахыг ГХЯ-ны удирдлагуудад зөвлөсөн байна. Үүнд:

- Монгол Улсаас гадаад оронд суугаа ДТГ-уудын өөрийн эзэмшлийн байруудын ашиглалтыг сайжруулахад зориулсан төсөв хөрөнгийн асуудлыг ээлж дараатай шийдвэрлүүлэх талаар арга хэмжээ авч ажиллах,
- Аудитын явцад хийсэн судалгаагаар зарим орны хувьд автомашиныг түрээсээр ашиглах нь улсын төсөвт дарамт багатай, эдийн засгийн ач холбогдолтой байх нөхцөлийг судлах,
- ДТГ-ын ажилтнуудын хувийн эзэмшлийн автомашинд олгосон дипломат дугаарын олголт, бүртгэлд тавих хяналтыг сайжруулах,
- ДТГ-ын ажилтнуудын цалин тогтоох нэгжийг холбогдох хуульд нийцүүлэн шинэчлэн боловсруулж, батлуулах,
- Аудитаар илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлууд нь өргөн тархацтай, эрсдэл үүсгэж байгаа ДТГ-уудын үйл ажиллагаанд дотоод хяналт хэрэгжүүлэх,
- Гадаад харилцааны яамнаас ДТГ-дад ашиглах нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан, арга зүйгээр хангаж мөрдүүлэх,
- Монгол Улсаас гадаад оронд суугаа ДТГ-т ажиллах дипломат ажилтнуудын “албан тушаалын тодорхойлолт”-ыг шинэчлэн боловсруулж, мөрдөх, дипломат албан тушаал эрхлэх болзол болон мэргэжлийн бэлтгэл хангасан албан тушаалтныг томилж байх,
- Гадаад оронд суугаа ДТГ-уудаас Монгол Улсад зорчих виз олголтод байнгын хяналт тавих цахим мэдээллийн системтэй болох,
- ДТГ-уудад эрсдэлд суурилсан дотоод аудит, хяналтыг хэрэгжүүлэх, үр дүн, үр өгөөжийг тооцож ажиллах.

Аудитаар нийт 22,229.6 сая төгрөг буюу 8,408.6 мянган ам.долларын алдаа, зөрчил илрүүлж, 533.0 сая төгрөг буюу 201.6 мянган ам.долларын алдааг аудитын явцад залруулж, 1,548.1 сая төгрөг буюу 585.6 мянган ам.долларыг улсын төсөвт төлүүлэхээр төлбөрийн акт тогтоож, 13,259.6 сая төгрөг буюу 5,015.6 мянган ам.долларын алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх талаар холбогдох ДТГ-дад 21, Гадаад харилцааны яаманд 3, ТӨБЗГ-т 1 албан шаардлага хүргүүлж, 6,888.9 сая төгрөг буюу 2,605.8 мянган ам.долларын алдаа зөрчлийг давтан гаргахгүй ажиллах нийт 127 зөвлөмж өгсөн байна.

Үүнээс 2019 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд аудитаар нийт 1,497.2 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж, 181.7 сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 357.3 сая төгрөгийг улсын төсөвт төлүүлэхээр төлбөрийн акт тогтоож, 421.2 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх талаар албан шаардлага хүргүүлж, 510.1 сая төгрөгийн алдаа зөрчлийг давтан гаргахгүй ажиллах нийт 41 зөвлөмж өгч, 26.9 сая төгрөгийн ажил гүйлгээг хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн байна.

2019 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлангийн аудитаар Гадаад оронд суугаа ДТГ-т тогтоосон 357.3 сая төгрөгийн актыг бүрэн барагдуулсан, 421.2 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлснийг 78.0 хувьтай биелүүлж, 41 зөвлөмж өгснөөс 28 зөвлөмжийг хэрэгжүүлж, зөвлөмжийн хэрэгжилт 73.0 хувьтай байна.

Аудитад Монгол Улсаас гадаад оронд суугаа ЭСЯ 18, Ерөнхий консулын газар 6, БТГ 2 хамрагдсанаас 15 ДТГ-ын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд “Зөрчилгүй”, 10 ДТГ-ын тайланд “Хязгаарлалттай”, 1 ДТГ-ын тайланд “Сөрөг” санал дүгнэлт өгсөн байна.

Үүнд:

А. “Зөрчилгүй” дүгнэлт /Будапешт, Бишкек, Бээжин, Вена, Женев, Канберра, Оттава, Стокгольм, Улаан-Үүд, Сөүл, Токио, Осака, Кызыл, Кувейт, Пхеньян/;

Б. “Хязгаарлалттай” дүгнэлт /*Вашингтон, Гавана, Дели, Кайр, Сингапур, Лондон, Нью-Йорк, Пусан, Москва, Эрээн*/

В. “Сөрөг” дүгнэлт /*Хөх хот / өгсөн байна.*

ДТГ-уудын дотоод хяналт хангалтгүйгээс өмнөх аудитаар илэрсэн алдаа, зөрчил давтагдсан, ГХЯ-ны ХШҮДАГ нь үйл ажиллагааны цар хүрээ ихтэй, хөрөнгийн маргаантай болон эрсдэлтэй газруудад хяналт хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Гадаад харилцааны яамны Санхүү, эдийн засгийн хэлтсээс гадаад оронд суугаа ДТГ-ын нягтлан бодогч нарт өгөх сургалт, мэргэжил арга зүйн зөвлөгөө, санхүүгийн бүртгэл, тайлагналд тавих хяналт хангалтгүйгээс санхүүгийн тайланг өмнөх оны үзүүлэлттэй зэрэгцүүлэхүйц хэлбэрээр гаргаагүй, тодруулга тайлангууд, төсвийн гүйцэтгэлийн тохируулга тайлан бэлтгээгүй, улсын төсөвт төвлөрүүлсэн орлогыг буруу тайлагнадаг, хөрөнгө, бараа материалын тайлангийн үлдэгдэл санхүүгийн тайлангийн үлдэгдлээс зөрүүтэй илэрхийлдэг зөрчлүүд арилахгүй давтагдсан байна.

Төсвийн шүүд захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар

Харьяа төсвийн 2 байгууллагын санхүүгийн тайланд аудит хийж, Зөрчилгүй 1, Хязгаарлалттай 1 /ЮНЕСКО-гийн Монголын үндэсний комисс/ дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 307.1 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 174.2 сая төгрөгийн алдааг залруулж, 20.5 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 12.9 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага, 99.5 сая төгрөгийн алдаа, зөрчилд 7 зөвлөмж өглөө.

Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлангийн аудитаар

Харьяа төрийн болон орон нутгийн өмчит 2 аж ахуйн нэгж байгууллагаас 1 санхүүгийн тайланг түүвэрт хамруулж, Зөрчилгүй 1 дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 319.5 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 250.0 сая төгрөгийн алдааг залруулж, 69.5 сая төгрөгийн алдаа, зөрчилд 7 зөвлөмж өглөө.

Тусгай сангийн санхүүгийн тайлангийн аудитаар

Олон улсын хамтын ажиллагааны сан Засгийн газрын 2019 оны 87 дугаар тогтоолоор татан буугдсан бөгөөд тайлант онд ажил гүйлгээ гараагүй, хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдэд туслах сангийн санхүүгийн тайланг аудитад түүврээр хамруулж, аудитаар зөрчил илрээгүй болно.

2.10. ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Авлагын үлдэгдэлд бүртгэлтэй олон жилийн насжилттай 1,787.7 сая төгрөгийн авлага анхаарал татахуйц чухал асуудал байна. Дараагийн аудитаар авлагыг барагдуулах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээнд горим сорил гүйцэтгэнэ.

ГХЯ-ны санхүүгийн тайлангийн дуусаагүй барилга дансанд бүртгэлтэй “Ёслол хүндэтгэлийн өргөө”-ний барилга угсралтын ажил дуусаж 2017 оны 10 дугаар сард ашиглалтад оруулсан боловч анхны гүйцэтгэгч болох “Хөмөтэ” ХХК-тай барилгын гүйцэтгэлийн талаар маргаан үүсгэсэн шүүхийн асуудал эцэслэгдээгүй асуудлыг дараагийн аудитаар нарийвчлан авч үзэх шаардлагатай гэж үзлээ.

2.11. ШИЛЭН ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ

Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагууд Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 5,903 мэдээллийг хугацаанд нь, 983 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 118 мэдээллийг байршуулаагүй бөгөөд хуулийн хэрэгжилтийн хувь 98.3, чанарын үнэлгээ 84.3 хувьтай үнэлэгдсэн байна.

ГХЯ-ны Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын 2019 оны ажлын тайланд дурдсанаар ГХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд улирал бүр хяналт, үнэлгээ хийж тухай бүрд нь холбогдох заавар зөвлөмжийг хүргүүлж ажилласны үр дүнд Шилэн дансны цахим мэдээллийн санд хуулийн хугацаанд нь байршуулсан мэдээлэл 10.5 хувиар өсөж, хугацаа хоцорсон мэдээлэл 10.7 хувиар буурсан, байршуулаагүй мэдээлэл өмнөх оноос 0.2 хувиар өсжээ.

Тус байгууллагын “Шилэн дансны тухай” хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан бөгөөд хуулийн хэрэгжилтийг “хангалттай” гэж үзлээ.

2.12. ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн ерөнхийлөн захирагчид өгсөн 512.1 сая төгрөгийн зөрчилд 5 төлбөрийн акт тогтоосноос 100 хувь барагдуулсан, 324.0 сая төгрөгийн зөрчлийг арилгах 4 албан шаардлага хүргүүлснээс албан шаардлагыг 96.7 хувьтай хэрэгжүүлсэн байна.

Нийт 17 зөвлөмж өгснөөс 13 зөвлөмжийг хэрэгжүүлж, 3 зөвлөмж хэрэгжих шатанд, 1 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй буюу зөвлөмжийн хэрэгжилт 88.7 хувьтай байна.

2.13. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Залруулагдаагүй 3,176.5 сая төгрөгийн алдаа, зөрчил нь бидний тогтоосон 3,215.3 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс бага тул “Зөрчилгүй” дүгнэлтийг өгч байна.

Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн мөнгөн гүйлгээ, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд Менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн нэгтгэсэн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Балансын данстай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд эрхлэх асуудлын хүрээний 8 байгууллага, нэгжийн санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс Монголын мянганы сорилтын сан ТӨҮГ-ын санхүүгийн тайлан аудит хийгдэлгүйгээр нэгтгэгдэн тайлагнагдсан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4-т "Төсвийн байгууллага нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу санхүүгийн тайланг тайлагнаж, тушаана", Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.2-т "Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллагын санхүүгийн тайлан, Засгийн газрын шугамаар авч, ашиглаж байгаа хөнгөлөлттэй зээл болон буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн санхүүгийн тайлан, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн санхүүгийн тайланг санхүүгийн нэгтгэсэн тайланд хамааруулна", мөн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д "Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд жилийн эцсийн санхүүгийн тайлангаа дараа жилийн 02 дугаар сарын 15-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн тайланг 3 дугаар сарын 15-ны дотор харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагч болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

3.1.2 Эрсдэл:

Санхүүгийн тайлан алдаатай нэгтгэгдэх, буруу илэрхийлэгдэх

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Харьяа байгууллага, нэгжүүдийн санхүүгийн тайланг аудитад хамруулах, аудит хийсэн тайланг нэгтгэж байх

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

3.2 Удирдлагын дээд болон дотоод хяналттай холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт:

ТЕЗ-ийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн авлага, өр төлбөрийн дансны үлдэгдлийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад авлага 8,908.1 сая, өр төлбөр 10,265.0 сая төгрөгөөр тус тус өссөн бөгөөд авлагын 16.4 хувь буюу 2,301.2 сая, өглөгийн 6.8 хувь буюу 875.3 сая төгрөгийг тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй, баталгаажуулаагүй авлагаас 1,651.1 сая төгрөг нь 10 жилийн өмнө үүссэн найдваргүй болох эрсдэлтэй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-т "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.6-д: "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-т "Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", санхүүгийн тайлангийн "оршин байх", "Эрх ба үүрэг" гэсэн батламж мэдэгдэлтэй тус бүр нийцэхгүй байна.

3.2.2 Эрсдэл:

Авлага өглөгийг тооцоо нийлээгүй байх, найдваргүй авлага үүсэх, өглөг төлөгдөхгүй байх

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Авлага, өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлж, баталгаажуулах, батлагдсан төсөвт хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ зарцуулалтад нь хяналт тавьж, ажил гүйлгээний үлдэгдлийг баталгаажуулж, төлөх боломжтой өр төлбөрийг тайлант онд нь барагдуулж байх, олон жилийн насжилттай авлагад анхаарал хандуулан барагдуулах арга хэмжээг зохион байгуулах;

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

3.3 Батлагдсан төсөв, гүйцэтгэлтэй холбоотой асуудал

3.3.1 Илрүүлэлт:

ГХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны төсвийн гүйцэтгэл 67,808.0 сая төгрөг бөгөөд батлагдсан төсөвт зардал 8,464.8 сая төгрөгөөр зарцуулагдаагүй үлджээ. Төсвийн гүйцэтгэлээр зардал бүлгийн дүнгээр хэтрээгүй боловч үндсэн цалин 1,741.2 сая, шуудан холбоо 39.0 сая, багаж хэрэгсэл 21.7 сая, тавилга 37.1 сая, дотоод томилот 2.6 сая төгрөгөөр тус бүр батлагдсан төсвөөс хэтэрсэн байна. Мөн сүүлийн 3 жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланг шинжлэхэд төсвийн тухай хуулиар батлагдсан төсөвт зардлын санхүүжилт 91-99 хувийн олголттой боловч зардлын гүйцэтгэл 85.0-94.0 хувийн биелэлттэй байна. Жил бүр ТЕЗ-ийн төлөвлөгөөг батлахдаа өмнөх оны гүйцэтгэлээс 15-20 хувиар, өмнөх оны төлөвлөгөөнөөс 6.0-9.0 хувиар илүү төсөвлөсөн боловч зарцуулагдаагүй үлдэгдэл 3,828.3-10,461.3 сая төгрөг байна. ГХС-ын 2019 оны 08/6836 болон 8/7397 албан бичгээр батлагдсан зарим зардал хүрэлцэхгүй байгаа тул журмын дагуу зардал хооронд зохицуулалт хийж, 2019 оны төсвийн хуваарьт өөрчлөлт оруулахаар Сангийн яаманд хандаж, ДТГ 1,827.7 сая, ГХЯ 853.2 сая төгрөгийг тус бүр зардал хооронд гүйлгэн шилжүүлж зарцуулсан зэрэг нь төсөв үндэслэл муутай хийгдсэнийг илтгэж байна. Сүүлийн 3 жилд төсөвт байгууллагын өөрийн орлогыг 1,550.0 сая төгрөгөөр тогтмол баталсан бөгөөд 2018 онд төлөвлөгөө 813.5 сая төгрөгөөр тасарсан бол 2019 онд 4,184.6 сая төгрөгөөр давуулан

биелүүлж, давсан орлогоос эрх нээлгэн 3,575.9 сая төгрөгийг зарцуулсан байна. Эдгээр нь төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.6-д "Төсөв захирагчийн үйл ажиллагаа, хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээний урсгал болон хөрөнгийн зардлыг төлөвлөх, гүйцэтгэлийн хяналт хийхдээ холбогдох норм, норматив, батлагдсан стандарт, зураг төсвийг үндэслэнэ" гэсэнтэй нийцэхгүй байна.

3.3.2 Эрсдэл:

Төсвийн төлөвлөлт үндэслэл муутай хийгдэх, орлого дутуу төвлөрүүлэх, үр ашиггүй, зориулалт бусаар зарцуулсан байх

3.3.3 Өгсөн зөвлөмж:

Жил бүр төсөвт тусгагдсан ч хэрэгжихгүй байгаа арга хэмжээний зардлыг бууруулах, зардал хооронд гүйлгэн зарцуулсан холбогдох зардлуудыг үнэн зөв, бодитой тооцоололд үндэслэн төсвийн төслийг боловсруулж, Сангийн яаманд хүргүүлэн төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төсөвлөх

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

3.4 Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэл

3.4.1 Илрүүлэлт:

Гадаад харилцааны яамны нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг нь 2013 онд боловсруулагдсан бөгөөд 2013 оноос хойш өөрчлөгдсөн хууль тогтоомж, Сангийн сайдын баталсан болон бусад батлагдсан заавар журмын өөрчлөлтийг тусгаагүй байгаа нь нягтлан бодогчид болон гадаад оронд суугаа Дипломат төлөөлөгчийн газруудын санхүүгийн ажилтнууд мэргэжлийн бус хүн ажиллаж байгаа бөгөөд тэдэнд баримтлах бодлого, арга зүй, гарын авлага дутмаг байгаагаас бүртгэлийн алдаа үүсэх эрсдэл ихтэй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 18.2-т "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана", 20 дугаар зүйлийн 20.2.11-т "Өөрийн шууд удирдлагын доор ажиллаж байгаа нягтлан бодогчдын ажлын гүйцэтгэлийг хянах, мэргэшүүлэх, сургалтад хамруулах арга хэмжээ авах" гэсэнтэй тус бүр нийцэхгүй байна.

3.4.2 Эрсдэл:

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох стандартын шаардлага хангаагүй байх

3.4.3 Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг өөрийн байгууллагын онцлогийг тусгасан бүртгэл, эрх зүйн актаар шинэчлэн сайжруулах, онлайн сургалт зохион байгуулж, арга зүйгээр хангах, ДТГ-ын санхүүгийн ажилтнуудын хариуцлагыг сайжруулах талаар арга хэмжээ авч ажиллах;

3.4.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

3.5 Дотоод хяналт, Аудитын акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

3.5.1 Илрүүлэлт:

Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтыг үнэлэхэд дотоод хяналт үр нөлөөтэй боловч өмнөх аудитаар илэрсэн нийтлэг алдаа зөрчил давтагдсан бөгөөд түүнийг арилгах талаар арга хэмжээ авч ажиллаагүй байна. Иймд харьяа байгууллагуудад онлайн сургалт зохион байгуулж, зөвлөмж зөвлөгөө өгөх, аудит хийх эрсдэлээ оновчтой тодорхойлж, үйл ажиллагааны цар хүрээ ихтэй, хөрөнгийн маргаантай болон хэвлэл мэдээллээр гарч буюу залилангийн шинжтэй асуудалд анхаарал хандуулан аудитын төлөвлөгөөндөө тусгаж ажиллах нь үр өгөөжтэй гэж үзэж байна.

3.5.2 Эрсдэл:

Дотоод аудитын ажил хангалтгүй байх, дотоод хяналт сул байх

3.5.3 Өгсөн зөвлөмж:

ХҮШДАГ нь эрсдэлд суурилсан дотоод хяналтыг хэрэгжүүлэх, санхүүгийн ажилтнуудад арга зүйн зөвлөгөө өгөх, сургалт зохион байгуулах, аудитаар өгөгдсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг төсвийн хуулийн хугацаанд гаргуулж, нэгтгэж, үнэлж, хэрэгжилтийг хангаж, биелэлтийг тооцож байх;

3.5.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2020 оны 9 дүгээр сарын 01-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

| Код: | Тайлангийн үзүүлэлт | 2018 оны 12-р сарын 31 | 2019 оны 12-р сарын 31 |
|--------------|---|------------------------|------------------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 13,361,615.6 | 25,691,881.7 |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 6,234,582.9 | 7,569,798.4 |
| 33 | АВЛАГА | 5,055,960.7 | 13,964,068.0 |
| 34 | УРЬДЧИЛГАА | 32,966.0 | 330,554.4 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 2,038,106.1 | 3,827,460.9 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 381,049,062.7 | 361,478,555.4 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 381,049,062.7 | 361,478,555.4 |
| 39100 | Газар | 33,342,495.7 | 33,342,495.7 |
| 39200 | Биет хөрөнгө | 319,862,751.2 | 300,325,940.1 |
| 39300 | Биет бус хөрөнгө | 27,843,815.9 | 27,810,119.5 |
| 39400 | Бусад хөрөнгө /ТӨҮГ/ | 0.0 | 0.0 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 394,410,678.3 | 387,170,437.1 |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | 783,564.9 | 11,048,610.7 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 783,564.9 | 11,046,848.0 |
| 41300 | Өглөг | 783,564.9 | 11,043,062.8 |
| 41400 | Урьдчилж орсон орлого | 0.0 | 3,785.2 |
| 42 | УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 0.0 | 1,762.7 |
| 42200 | Урт хугацаат зээл | 0.0 | 1,762.7 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 393,627,113.4 | 376,121,826.4 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 393,627,113.4 | 376,121,826.4 |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 201,783,211.0 | 201,762,839.7 |
| 51200 | Хуримтлагдсан үр дүн | -54,181,058.8 | -73,769,789.0 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 261,220,560.0 | 261,220,560.0 |
| 51400 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | -15,195,598.8 | -13,091,784.2 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 394,410,678.3 | 387,170,437.1 |

4.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

| Код: | Тайлангийн үзүүлэлт | 2018оны 12-р сарын 31 | 2019 оны 12-р сарын 31 |
|------------|--|-----------------------|------------------------|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 105,115,142.9 | 140,691,583.50 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 32,966,540.7 | 62,091,964.3 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 32,966,540.7 | 37,770,199.9 |
| 122 | Тусламжийн орлого | | 24,321,764.5 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 72,148,602.2 | 78,599,619.2 |
| II | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 113,259,780.1 | 160,060,874.3 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 111,654,854.7 | 159,979,578.4 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 74,740,502.2 | 123,169,507.2 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 26,885,143.9 | 29,414,832.3 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 1,047,884.4 | 993,540.7 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 12,279,133.0 | 14,055,182.7 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 2,248,410.0 | 2,328,273.1 |
| 2105 | Нормативт зардал | 12,257.3 | 9,350.9 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 1,223,720.0 | 716,446.9 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 6,072,855.6 | 5,727,248.2 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 12,886,280.8 | 34,880,586.6 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 12,084,817.3 | 35,044,045.8 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 36,914,352.4 | 36,810,071.3 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 1,604,925.4 | 81,295.8 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II) | -8,144,637.2 | -19,369,290.7 |
| IV | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН | 6,738.0 | 334,028.2 |
| V | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 19,682,725.5 | 704,757.1 |
| VI | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V) | -27,820,624.7 | -19,740,019.6 |

4.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

| Код: | Тайлангийн үзүүлэлт | 2018оны 12-р сарын 31 | 2019 оны 12-р сарын 31 |
|-------------|---|-----------------------|------------------------|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I) | 105,856,272.0 | 133,988,947.2 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 32,469,884.8 | 50,527,717.4 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 32,469,884.8 | 35,171,998.1 |
| 122 | Тусламжийн орлого | 0.0 | 15,355,719.3 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 73,386,387.1 | 83,461,229.7 |
| II | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 104,989,924.1 | 124,380,236.7 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 104,989,924.1 | 124,380,236.7 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 66,622,088.9 | 87,314,497.1 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 26,792,781.4 | 30,351,499.0 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 1,304,329.1 | 1,399,395.0 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 14,188,730.3 | 15,992,480.8 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 3,083,480.4 | 2,949,355.0 |
| 2105 | Нормативт зардал | 15,488.0 | 14,457.7 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 1,238,695.4 | 678,774.4 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 5,792,167.1 | 5,535,382.1 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 10,011,006.9 | 22,274,755.1 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 4,195,410.4 | 8,118,398.1 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 38,367,835.2 | 37,065,739.6 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II) | 866,347.8 | 9,608,710.5 |
| IV | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV) | - | 142,140.6 |
| V | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V) | 2,509,047.6 | 7,326,203.0 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 2,509,047.6 | 7,326,203.0 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 2,509,047.6 | 7,326,203.0 |
| VI | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V) | -2,509,047.6 | -7,184,062.3 |
| VII | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН | -471,614.1 | -1,089,432.6 |
| 14 | Бусад эх үүсвэр | 1,102.6 | 146,960.0 |
| 25 | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ | 472,716.7 | 1,236,392.6 |
| VIII | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII) | -2,114,313.9 | 1,335,215.5 |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 8,348,896.8 | 6,234,582.9 |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 6,234,582.9 | 7,569,798.4 |

4.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

| Код: | Тайлангийн үзүүлэлт | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн | Цөөнхийн хувь оролцоо | Нийт цэвэр хөрөнгө/өмч |
|------|---|--|-----------------------|------------------------|
| 1 | 2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 115,219,676.1 | - | 115,219,676.1 |
| 2 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | -5,082,320.3 | - | -5,082,320.3 |
| 3 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 110,137,355.8 | - | 110,137,355.8 |
| 4 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | 256,134,335.3 | - | 256,134,335.3 |
| 5 | Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт | 86,480,831.6 | - | 86,480,831.6 |
| 6 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | -31,304,784.6 | - | -31,304,784.6 |
| 7 | Өмчид гарсан өөрчилөлт | 0.0 | - | 0.0 |
| 8 | Зарласан ногдол ашиг | 0.0 | - | 0.0 |
| 9 | Тайлант үеийн үр дүн | -27,820,624.7 | - | -27,820,624.7 |
| 10 | 2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 393,627,113.4 | - | 393,627,113.4 |
| 11 | 2019 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 393,627,113.4 | - | 393,627,113.4 |
| 12 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 168,997.1 | - | 168,997.1 |
| 13 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 393,796,110.6 | - | 393,796,110.6 |
| 14 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | - | - | - |
| 15 | Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт | - | - | - |
| 16 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 2,103,814.6 | - | 2,103,814.6 |
| 17 | Өмчид гарсан өөрчилөлт | -20,371.4 | - | -20,371.4 |
| 18 | Зарласан ногдол ашиг | -17,707.7 | - | -17,707.7 |
| 19 | Тайлант үеийн үр дүн | -19,740,019.6 | - | -19,740,019.6 |
| 20 | 2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 376,121,826.4 | - | 376,121,826.4 |

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Төсвийн гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|-------------|--|---------------------|---------------------|--------------------|-------------|
| II | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 76,272,820.0 | 67,808,015.5 | 8,464,804.5 | 88.9 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 73,397,820.0 | 64,941,069.0 | 8,456,751.0 | 88.5 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 69,759,821.0 | 62,755,904.1 | 7,003,916.9 | 90.0 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 29,013,822.9 | 26,966,825.2 | 2,046,997.7 | 92.9 |
| 210101 | Үндсэн цалин | 24,447,942.3 | 26,189,149.9 | -1,741,207.6 | 107.1 |
| 210102 | Нэмэгдэл | 4,439,946.3 | 652,480.4 | 3,787,465.9 | 14.7 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 125,934.3 | 125,194.9 | 739.4 | 99.4 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 1,239,265.3 | 821,676.1 | 417,589.2 | 66.3 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 1,148,330.5 | 730,909.7 | 417,420.8 | 63.6 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 22,590.1 | 22,413.8 | 176.3 | 99.2 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 18,072.0 | 18,072.0 | 0.0 | 100.0 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 4,518.0 | 4,530.7 | -12.7 | 100.3 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 45,754.7 | 45,749.9 | 4.8 | 100.0 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 14,209,874.1 | 13,430,246.7 | 779,627.4 | 94.5 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,341,085.0 | 961,472.5 | 379,612.5 | 71.7 |
| 210302 | Түлш, халаалт | 1,376,267.1 | 1,148,288.9 | 227,978.2 | 83.4 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 623,866.3 | 503,047.1 | 120,819.2 | 80.6 |
| 210304 | Байрны түрээс | 10,868,655.7 | 10,817,438.3 | 51,217.4 | 99.5 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 2,322,153.6 | 2,235,999.0 | 86,154.6 | 96.3 |
| 210401 | Бичиг хэрэг | 332,961.6 | 270,013.8 | 62,947.8 | 81.1 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,007,944.9 | 965,044.9 | 42,900.0 | 95.7 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 770,760.8 | 809,733.8 | -38,973.0 | 105.1 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 210,486.3 | 191,206.5 | 19,279.8 | 90.8 |
| 2105 | Нормативт зардал | 26,204.3 | 15,746.9 | 10,457.4 | 60.1 |
